



ТОРОН ЭСҮҮД БА ОРОН ЗАЙН ЭНТОРИНАЛ БҮТЭЦ ЗҮЙ

Нобелийн лекц, 2014 оны 12 сарын 7

Эдвард Мозер

Мэдрэлийн Тооцооллын Төв болон Системийн
Нейросайнсын Кавли Институт

Норвегийн Шинжлэх Ухаан, Технологийн Их
Сургууль, Норвеги улс

1. Сэтгэл судлалаас Нейрофизиологи хүрэх замд- Өнгөрсөн үе

1983 онд Мэй-Бритт бид хоёр Ослогийн их сургуульд оюутан байхдаа сэтгэл судлалын анги сонгож байлаа. Зан үйл түүний мэдрэлийн үндэс суурийг ойлгохыг хүсэж байв. Тухайн үед 1930, 1940, болон 1950-аад оны суралцахуйн онолыг ихэд сонирхож Ватсон, Холл, Скиннер, Толман нарын бүтээлийг судалж байлаа (Зур 1.). Сэтгэл судлалын тухайн үеийн ололт амжилт, суурь

ойлголт хэрэглээнд ашиглах, амьтны зан үйлийн урт хугацааны үр дагаврыг хянах хэмжээнд хүртлээ хөгжчихсөн байсан нь бидний анхаарлыг ихэд татаж байв.

Хэдийгээр зан үйлийн судалгаа бидний анхаарлыг ихэд татаж байсан хэдий ч ихэнх зан үйлийн онолыг тайлбарлах физиологийн судалгаа технологийн болоод онолын концепц байгаагүйгээс хол хоцорч үлдсэн нь харамсалтай хэрэг байсан. Зан үйл судлал оргилдоо хүрч байх үед Карл Лешлигийн ой санамжийн мэдрэлийн үндсийг тайлбарлахыг эрэлхийлсэн судалгаа тухайн үедээ зоригтой алхам байсан бөгөөд энэ үеэс л психологи болон физиологийн нэгдлийн эхлэлийг тавьсан байна (Лешли 1929, 1950). Гэхдээ Доналд О Хеббийн ажлаас 1940-өөд оны сүүлээс эхлэн зан үйлийн ойлголт зарчмын хувьд нейрофизиологитой холбогдож эхлэв (Хебб, 1949). Хеббийн эсийн нийлэмж, пластиситийн талаар гаргалгаа физиологи, психологийн салбарт суралцахуй, ой санамжийг судлах шинэ үеийг төрүүлсэн билээ. Суралцахуйг судлах энэхүү шинэ сонирхол дараа үедээ ой санамжийг тайлбарлах түлхүүр синапсийн механизмд хөтөлсөн ба 2000 онд Эрик Кандел Нобелийн шагнал хүртэв (Кандел, 2000).

Энэхүү нээлтийн цар хүрээ болох- суралцахуйн хууль болоод түүний синапсийн нарийн хэрэглээ Мэй-Бритт бид хоёрын анхаарлыг ихэд татсан. Физиологийг сэтгэл судлалд авчрах хүсэл биднээс ч өмнөх эрдэмтдийн хүсэл мөрөөдөл байсан (Зур 1.) төдийгүй энэхүү зам бид хоёрын урт аяллын эхлэл бөгөөд, бидний багш нар, хамтран зүтгэгчид ялангуяа бидний докторын ажлын удирдагч Пер Андерсон зэрэг олон хүний тус дэмээр биеллээ олсон.




ЗУРАГ 1. 2014 оны Анагаах ухаан, физиологийн салбарын гурван Нобелийн шагналтнууд бүгд Е.К. Толманы мөрийг түших учиртай. Толман 1930-аас 1950-аад онуудад төрөл бүрийн төөрдөг замуудаар харх гүйх туршилт явуулж гадаад орчны талаар амьтан дотоод газрын зураглал үүсгэдэг хэмээн үзсэн. Ийнхүү газрын зураг буулгах нь оюун ухаант мэдлэг, танин мэдэхүйн газрын зураг хэмээгээд хүрээлэн орчинд өөрийн байрлалаас уялдан мэдээллийг хуримтлуулдаг гэсэн (Толман, 1948). Тиймээс Толман танин мэдэхүйн психологийн анхдагч байгааг зогсохгүй орон зай тархинд хэрхэн буудаг тухай судалсан юм. Гэхдээ Толман ямар нэгэн мэдрэлийн бүтэц, мэдрэлийн идэвхжлийг өөрийн онолдоо тусгаагүй бөгөөд энэ нь тухайн үеийн тархи-зан үйлийг холбогдолыг тайлбарлах ойлголт, аргачлалын төвшиндөө тохирч байсан билээ. Амьдралынхаа сүүлийн мөчид тэрбээр зан үйлийн нейросайнсд ихээхэн итгэл тавьж байсан. 1958 онд Лешли нас барсны дараа тэрбээр Доналд О. Хеббээс ирсэн дээхэн үед зан үйл ид мандсан үеийн физиологийн талаар өөрийнх нь хандлагыг асуусан захидалд хариу болгон “Би тухайн үед яах аргагүй анти-физиологи үзэлтэй байсан, үүгээрээ ч бахархдаг. Гэхдээ өнөөдөр энэхүү баримтлал (физиологчлол) шинийг авчирна гэдэгт итгэж байна” хэмээсэн байдаг. Зураг: Сэтгэл судлалын тэнхимд хадгалагдаж байна, Беркели КИС. Захидал: Стиви Гликман, Беркели КИС.

Хеббийн физиологийн баримтлалаас ангид, физиологийн анхдагчид болсон Давид Хюбел, Торстен Виесел (Зур 2.) нар

психологи-физиологийн заагийг 1950-аад онд бидний уураг тархины чухал хэсэг болох их тархины бор гадрын ширхэг нейроны идэвхжлийг бүртгэх замаар нурааж байв. Сэрүүн амьтдын харааны гадарт электродууд байрлуулж харааны зураглалын элементүүд бие даасан өөр нейронуудад хамааралтай болохыг нээсэн байна (Хюбел ба Виесел, 1959, 1962). Энэ ажил харааны мэдрэхүйн үндсийг тайлбарлах олон арван жилийн судалгааны эхлэлийг тавьж, гадрын тооцоолол хэмээх шинэ салбар бүрэлдэхэд тусалсан. Харааны гадрын доод төвийг илрүүлснээр их тархины гадар хэрхэн ажилладаг байж болох сэжмийг бий болгожээ. Хюбел, Виесел нарын ажлын дүнд өнөөдөр харааны кодлох механизмын хэсгийг тайлсан бөгөөд тэдний ажил эхэлснээс бараг 60-аад жилийн дараа гэсэн үг юм.




ЗУРАГ 2. Дэвид Х.Хюбел, Торстен Н.Виесел нар физиологи-сэтгэл судлалын заагийг физиологийн талаас нэвтэрсэн. Харааны бор гадаргын доод түвшний мэдрэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлсон ба мэдрэмж, мэдрэхүй гэх мэт сэтгэл судлалын ойлголтыг тодорхой чиг үүрэгтэй эсүүдийн хоорондын харилцан үйлчлэлээр дамжуулан тайлбарлаж болно гэдгийг харуулсан. Торстен Н.Виссел нарын хүндэтгэлд зориулав.



ЗУРАГ 3. Харааны гадрын шаталсан зураглал нь доод хэсэгтээ нүдэнд ирэх мэдээллээс (RGC, торлогын зангилааны эсүүд, LGN, гадар өвдгөн бөөм) эхлэх бол энторинал гадар (ER) ба Гиппокампад (HC) дээшээ хүрч төгсөнө. Хюбел болон Виезелийн ажил нь шатлалын доод түвшинд шинэ ойлголтыг бий болгосон. Шатлал дээшлэх үед мэдрэлийн үйл ажиллагаа ба гадаад ертөнцийн байдал, үйл явдлын хоорондын хамаарал түргэн арилдаг. Гипокамп-энторинал зайны системийн эсүүдээс шатлалын оргилд байгаа нь бусдаас онцгой ялгаатай байдаг. Феллеман ба вон Эссэн (1991) нарын зөвшөөрөлтэйгээр дахин хэвлэв.

Гэсэн хэдий ч, бидний мэдлэг мэдрэхүйн системийн эхний хэсэг болох сэрэл хүлээн авах түвшинд л хязгаарлагддаг. Гадрын шатлал дээшлэх тугамд (Зураг 3) гадаад ертөнцтэй холбоотой байдлыг сайн ойлгож амжаагүй байгаа ба эрдэмтэд бид төөрөгдсөн

эсвэл судлахаас зайлсхийж байна. Гэхдээ хэд хэдэн онцгой нөхцлүүд байна. Харааны тогтолцооны дээд төвшинд хэд хэдэн энгийн элементүүдийн нарийн нийлэмжид хариулдаг эсүүд байгаа ба эдгээр нь мөн гар нүүр зэрэг чухал хэсгүүдтэй уялдана. (Gross et al., 1969, 1972; Bruce et al., 1981; Perrett et al., 1982; Tanaka et al., 1991; Tsao et al., 2005). Хамгийн хачирхалтай жишээ бол мэдрэхүйн шатлалын оргил болох гипокампад гадраас улам гүн рүү орохтой зэрэгцэн мэдэж болно. 1971 онд Жон О'Кэфэ ба Жон Достровски нар тодорхой байрлалуудад амьтны гипокампын эсүүд өвөрмөцөөр идэвхжиж буйг илрүүлсэн. (O'Keefe and Dostrovsky, 1971; O'Keefe, 1976; Зур. 4). Жижиг орчинд эс болгон дохиолол дамжуулах нэг цэг байв. Ингээд нийтдээ ойрхон зэрэгцэн орших эсүүд хүрээлэн орчныг бүхэлд нь бүртгэж Толманы дотоод газрын зургыг тайлбарлах эсүүдийн байрлалыг тогтоосон (O'Keefe and Nadel, 1978). Мэдрэлийн эсүүдийн идэвхжил болоод гадаад орчны янз байдлын хүчтэй холбоог илрүүлсэн нь мэдрэхүйн эсүүд, хөдөлгөөний аппаратыг бүрэн тайлаагүй үед ч физиологи-психологийг тайлбарлах боломж ийнхүү бүрдсэн байна.




ЗУРАГ 4. Жон О'Кэфэ (зүүн гар талд) Гипокампад байрлах байран эсүүдийг илрүүлсэн (O'Keefe and Dostrovsky, 1971). Байран эсүүд бол (голын ба баруун) тухайн амьтан хүрээлэн орчинд тодорхой байршилд байх үед идэвхждэг эсүүд юм. Голын диаграммд дугуй хэлбэртэй бичлэгийн хашлага доторх амьтны туулсан замыг сааралаар харуулсан болно. Нэг ширхэг байран эс идэвхжсэн үед улаан цэгээр дүрслэв. Баруун гар талд ижил байран эсийн идэвхжлийг өнгөтөөр дүрслэв (цэнхэр, бага хувь, улаан, өндөр хувьтай). Илүү том орчинд байран эсүүд ихэвчлэн энторинал гадрын нэгээс олон талбайд идэвхждэг (Fenton нар, 2008). Ингээд та бүхэнд лекцийнхээ хоёр дахь хэсэгт торон эсүүдийн харилцан үйлчлэл, гадаад орчны геометр, торон эсийн зураглалын байрлал зүй, торон эсийн зургаан өнцөгт симметри механизмыг тайлбарлах болно.

2. Үл мэдэгдэх талбарт оров-Энторинал гадар

Гипокампын сүлжээ хэд хэдэн шатлалаас бүрддэг- үүнд шүдлэг ховил, СА3 ба СА1- эдгээр нь нэгэн чигийн дарааллаар гипокампын хөндлөн тэнхлэгтэй параллелээр их эсвэл бага холбогдоно. (Andersen et al., 1971; Зур. 5). Энэ эргэлтийн шат бүрт энторинал гадраас нэмэлт сэрэл хүлээн авдаг. 1990-ээд онд энторинал гадрын мэдрэлийн идэвхжлийн бичлэгүүдийг судалж эдгээр эсүүд өргөн бөгөөд тархмал талбайд дохиолол дамжуулдаг болохыг харуулсан ба гипокампын СА1 талбайн хурц, хязгаарлагдмал талбайгаас нэлээд ялгаатай юм. (Barnes et al., 1990; Quirk et al., 1992; Frank et al., 2000). Тухайн үед буюу 1990-ээд оны сүүлч хүртэл байрлалын дохиоллын тооцоолол эсвэл дор хаяж дохиолол хурцлагдах явц энторинал гадар болон СА1-ийн хооронд бүрэлддэг, гипокампын дотоод сүлжээ, үүнээс шүдлэг ховил ба СА3-ын төвшинд хэмээн таамаглан үздэг байв.

Гипокампын дотоод сүлжээнд байрлалын талбай бүрэлддэг эсэхийг тогтоохын тулд бид нейроанатомич Менно Виттер, дараа нь Амстердамын нээлттэй их сургуультай хамтран ажилласан. Бидний эхний төсөл бол гипокампын эхэн үед химийн идэвхгүйжүүлэх аргачлалаар СА1-ийг ялгасан явдал байв. (Brun et al., 2002; Зур. 5) СА1-ийг эрт үед нь ялгасны дараа зөвхөн энторинал гадрын шууд сүлжээг нотлох боломжтой болсон. Дотоод идэвхжлийн сүлжээг бүрэн ялгалгүй ажилласан хэдий ч СА1-ийн эсүүдийг ялган таних бололцоотой хэвээр байсан хэдий ч, хяналтын амьтадтай харьцуулахад идэвхжиж буй эсүүд нь барзгар, сарнисан харагдаж байв. (Зур 6.) Энэхүү үр дүнгээс үзэхэд орон зайн мэдээлэл нэг бол СА1 сүлжээнд дангаар боловсрогддог байж болох ба уг хэсэг нь дохиолол-хяналтын (feed-forward) систем давамгайлсан бүтэцтэй, түүнчлэн энторинал гадраас СА1-д ирж буй дохиолол СА3-аар дамжин ирдэг нь энэ таамаглалыг үгүйсгэхэд хүргэв. Таамаглалыг шийдвэрлэхийн тулд энторинал гадрын идэвхжлийг судлах нь чухал болов.




ЗУРАГ 5. Электродын байрлал ба энторинал гадарт хүрэх гипокампыг нээж гэмтэл үүсгэсэн туршилт (Brun et al., 2002). Дээд зурагт мэрэгчийн тархины бор гадрын доор cashew самрын хэлбэртэй гипокампыг дүрслэв. Доод зурагт гипокамдын хөндлөн зүслэгийг харуулж байна. Гипокампын чухал дэд нэгжүүд болох энторинал гадар (ento), CA3, CA1-ийг зааж харуулсан. Гипокампын сүлжээ холбоосууд нь ихэвчлэн нэг-чигийн бөгөөд энторинал гадраас шүдлэг ховилд, цаашлаад CA3, CA1-д чиглэдэг (дотоод сүлжээ), эсвэл энторинал гадраас шууд бусад дэд нэгж рүү хүрдэг, жишээлбэл CA1-д хүрэх замыг улаанаар харуулав. CA1-д байрлуулсан тетродын байрлалыг тэмдэглэсэн ба энэ нь уг талбайн эсийн байрлалыг заана (хурц байрлалыг улаан цэгээр, хар траектороор зур 4.-т үзүүлсэн), Хар баганаар Бран нарын судалсан CA1-ээс CA3-д хүргэх дотоод замыг гэмтээж судалсан байдлыг харуулав. Гипокампын загварыг Андерсен нарын диаграммыг түшиглэн зурав (1971).


Менно Виттертэй болоод бидний хоёр оюутан Марианне Фихн, Штурла Молден нартай хамтран ажиллаж дунд энторинал гадрын ар доод талд (энторинал гадрыг судалсан өмнөх судалгаануудаас хавь илүү хойд талд) электрод суулгав. Бид энторинал гадрын энэ талбайг сонгосон учир нь тухайн үед байрлал-эсийн идэвхжил хамгийн их бүртгэгдсэн гипокампын дорзал хэсгийн тусгал байсанд оршив (Brun et al., 2002; Зур. 5). Уг талбайн эсүүд дохиолол дамжуулах талбай нь бүрэн зааглагдаж

тодорхойлогдсон байна (Fuhn et al., 2004). Олон эсүүд гипокампын СА1-ийн байрлалын эсүүдтэй ижил хурц долгионтой идэвхжилтэй байсан боловч ялгаатай байв. (Зур. 7) Юун түрүүнд эс болгон дохиолол дамжуулах олон талбайтай юм. Хоёрдугаарт тухайн орчны талбай нь санамсаргүй бус, харин тодорхой зайтай зааглагдаж байв. Ийм давтамж тогтмол ажиглагдсан боловч бид алгоритмыг тайлбарлаж чадаагүй билээ.

(a)



(b)




ЗУРАГ 6. Гипокампын дотоод сүлжээ замыг гэмтээсний дараах СА1-ийн байрлалын эсүүд. (a) нэгэн амьтны тархинд үүсгэсэн гэмтэл болоод тетродууд байрлалыг Нисслийн-будгаар будаж коронал тэнхлэгээр зүсэж харуулав. Арын гипокампын СА3 бараг бүхэлдээ авхагдсан (гэмтэл үүсгэсэн талбарыг дөрвөлжин хайрцгаар харуулсан). Сумны толгойгоор СА1 пирамид эсийн

давхрын тетродын үзүүрийн байрлалыг заав. (b) Өнгөөр кодолсон эсийн идэвхжлийн зураглалаар CA1-ийн пирамид эсийн төлөөлөл 7 байрлалын талбайг дөрвөлжин нүднүүдэд харуулсан (улаан, хамгийн өндөр идэвхжил, хар хөх, идэвхжилгүй, өнгөний кодыг зур.4-г). (a) зураг дахь амьтны мэдээлэл. Бран нарын бүтээлээс зөвшөөрөлтэй нийтлэв (2002).

3. Торон эсүүд тэдгээрийн үйл ажиллагааны зохион байгуулалт


2005 онд Торкел Хафтинг, Марианне Фихн, Штурла Молден оюутнуудынхаа хамтаар идэвхжлийн бүтцийг бүтээж чадсан. Өмнөхөөсөө том талбайг хамруулж идэвхжлийн зүй тогтол үелэлтэй байгааг нотолсон (Хафтинг нар 2005). Эсүүдийн идэвхжлийн талбайнууд нь амьтны өөрийн оршиж байгаа орчныг буулгасан зөгийн үүр шиг, эсвэл хятад шатрын хөлөг шиг зургаан өнцөгт гексагон торыг бүтээж байв (Зур. 8). Олон тооны энторинал эсүүд ийнхүү идэвхжиж байсан учраас бид торон эсүүд хэмээн нэрийдсэн.



ЗУРАГ 7. Хархыг дөрвөлжин камерт хийгээд шоколадны үйрмэг хөөх үед бичлэг хийж байгаа байдал, уг бичлэгт дунд энторинал гадрын нэг эсийн идэвхжлийг харуулна. Нэг хурц долгион нь идэвхжил өгсөн байрлалд цагаан цэг болж тэмдэглэгдэнэ. Зургаас идэвхжлийн хэд хэдэн талбай байгааг харж болох бөгөөд хөрш талбай хоорондоо зай нь ижил ойролцоо тогтоцтой байна. Киног nobelprize.org сайтаас үзэж болно.

Бид тор-хашаа мэт зураглалаар эсүүд идэвхжиж байгааг хараад ихэд гайхал төрсөн ба ингэх болсон хоёр шалтгаан нь нэгдүгээрт амьтны мэдэрхүйд ийм зүй тогтол байхгүй тул уг зүй тогтол нь энторинал гадрын болон зэргэлдээх хэсгийн дотоод тогтоц болохыг харуулсан, хоёрдугаарт мөн ийм жигд бүтэцтэй тогтоц бол тархин доторх орон зайн газрын зургыг илэрхийлж байсан-гипокампын байрлалын зураглалын мэдэгдээгүй байсан хэмжүүр болов (О'Кэфэ, 1976).

Торон эсүүд дунд энторинал гадрын бүхий л эсийн давхаргад элбэг байршжээ (Sargolini et al., 2006). Ялангуяа эсийн II дугаар давхаргад торон эсийн шалгуур хангасан эсүүдийн тал хувь нь байрладаг. Гэхдээ торон эсүүд олон янз байдаг (Зур. 9). Ийнхүү ялгарах дор хаяж гурван параметр хувьсагч байдаг (Hafting et al., 2005). Хамгийн эхэнд эсүүд өөр фазуудад оршдаг, өөрөөр хэлбэл торны х у тэнхлэгтэй ямар харьцаатай оршдог вэ гэдгээрээ ялгагддаг. Хоёрт нь торон эсүүд хэмжээний хувьд ялгаатай бөгөөд орон зайн давтамж, талбайн хэмжээ, тэдгээрийн хоорондын зай зэргээр ялгаатай. Хамгийн жижиг торон эс жишээлбэл идэвхжил хоорондын зай 30-хан сантиметр байсан. Бусад эсүүд нь нэг метрээс хол орон зайн талбайг кодолдог. Эцэст нь торон эсүүд ялгаатай чиглэлүүдтэй байна, ж.н торны тэнхлэг нь хүрээлэн орчинд байгаа хананы жишиг тэнхлэгээс зөрүүтэй хэлбийлттэй байдаг.




ЗУРАГ 8. Торон эсийн идэвхжлийн чиглэл зам. (a) 220 см өргөн дөрвөлжин хашлага дотор 30 минутын турш амьтныг байлгахад энторинал торон эсийн орон зайн үечлэлтэй идэвхжсэн янз байдал. Хархны хөдөлгөөнийг саарлаар, бие даасан хурц долгион өгсөн байрлалыг хараар тэмдэглэв. (b) 1м өргөн хашлага доторх торон эсийн идэвхжил. Стенсола (2012) ба Хафтинг (2005) нарын ажлаас шинэчилж ашиглав.


Шинэ эсийн төрлүүдийг нээсний дараагаар бид торон зураглал ямар фазаар, ямар харьцаатай хэмжигдэхүүнээр зохион

байгуулагддаг талаар судлахаар сэтгэл шулуудсан билээ (Хафтинг нар, 2015). Та бүхэнд би эхлээд торон эсүүдийн фазыг тайлбарлаж үзүүлье, жишээ нь торон өнцөг үүсгэх байрлал зэргээс эхлэнэ. Зэргэлдээ оршдог эсүүл ижил фазад оршдог уу? Эсвэл фазын хамаарал санамсаргүй тохиолддог уу? хэмээх асуулт тулгарч байна. Ижил тетрод дээр бүртгэгдсэн эсүүд ерөнхийдөө өөр торны фазууд дээр оршдог (Зур 10.). Ижил тетродын эсүүдийн идэвхжлийн байрлал нь өргөн тархсан бусад тетродуудынхаас ижил зураглал барагтай үзэгдээгүй. Энэ үр дүнгээс тетрод техникийн нарийвчлалыг үзвэл орон зайн дүрслэлд торны фаз эсүүдийн топографи буюу байрлалаас хамааралгүй байна. Торон бүтцийн бүх фазууд энторинал сүлжээний жижиг хэсгүүдээс тогтдог юм. Ингэж тархсан хэлбэр зүй нь мэрэгчдийн чиг баримжаад өвөрмөц эсүүдийн ширээний давс-перц маягийн зохион байгуулалтыг санагдуулдаг ба ийм хэв маяг тархины гадрын хэд хэдэн хэсэгт байдгаас дурдвал пириформ гадрын үнэрийн зураглал эсвэл гипокампын байрлалын-эсийн зураглал зэрэг болно.


Grid phase




Grid scale



Grid orientation




ЗУРАГ 9. Торон эсүүд дотор дор хаяж гурван параметр хувьсагч ялгаатай байна, Үүнд торны фаз буюу тэнхлэг, торны хэмжээс пропорц, торны чиглэл зэрэг хамаарна. Фаз, хэмжээс, чиглэлийн ялгааг торны хослолуудаар харуулсан ба нэг торыг хөх, нөгөөг ногооноор дүрслэв. Торны фаз хэмээх ойлголт нь х-у тэнхлэгтэй ямар харьцаатайгаар дохиолол дамжуулдаг талбайн харьцааг хэлдэг бол торны хэмжээс гэдэгт дохиолол нэг талбайгаас нөгөөд хүрэх дохиолол дамжих эс хоорондын зайг, харин торны чиглэлд торны тэнхлэгийн өнцөг тухайн харгалзах гадаад орчны шугамтай (ж.н амьтанг хийсэн хайрцагны хана) үүсгэх өнцгийг ойлгоно.



ЗУРАГ 10. Торны фаз нь бидний судалсан тетродын аргачлалаар бол топографийн хамааралгүй ажээ. Зүүн талд тетрод болон дохиолол дамжуулж буй эсүүдийн байрлалыг харуулав. Гурван янз бүхий торон эсүүдийг өнгөөр ялгаж харуулсан. Баруун талд нэг тетродын байрлалд бүртгэгдсэн гурван торон эсүүдийн сүлжээг харуулж байна. Гурван эсүүдийн нарийвчилсан байрлалыг тетродын дохиоллоос бүрэн тодорхойлох боломжгүй юм. Хафтинг нарын бүтээлээс (2005).

Торны фазаас ялгаатай нь торны пропорц хэмжээс топограф байрлалын хувьд макроскопийн төвшинд буудаг байна. Ихэнхдээ торны орон зайн хэмжээс нь дорзал буюу ар талаасаа өвөр дотор талын энторинал гадар чиглэд ихэснэ. Электрод доошлох тутамд торны дундаж хэмжээ өссөн ба орон зайн томъёолол нь ч даган өсөж, ялгаралтай байжээ (Зур 11.). Өмнөх үеийн судалгаануудаас энэхүү торны хэмжээсний өсөлт нь жигд, аамимдаа, эсвэл үл мэдэгдэх шатлалаар өсдөг эсэхийг хэлэх боломжгүй байлаа. Дээжинд ялгах боломжтой эсийн тоо хязгаарлагдмал байсан тул бид амьтан бүрийн мэдээллийг дундажлан (Фихн нар, 2004, Хафтинг нар 2005.) судалсанаар шатлал-бүхий зарчмаар амьтан бүрт нэмэгдэж байгааг анзаарсан.



ЗУРАГ 11. Торны хэмжээсийн топографийн зохион байгуулалт. Зурагт улаанаар тархины медиал энторинал гадрын сагиттал зүслэгийг улаанаар тодруулав. Медиал энторинал гадрын дорзо-вентрал чиглэлд гурван торон эсийг бүртгэж авсан идэвхжлийн зураглалын харуулж байна. Дорзо(ар талаас)-вентрал (өвөр) тэнхлэг дагуу жижиг хэмжээнээс том хэмжээст шилжиж буйг анзаарна уу? Стенсола нарын бүтээлээс (2012).

2012 онд Ханне ба Тор Стенсола болоод бусад оюутнуудынхаа хамтаар торны хэмжээсийн өөрчлөгдөх зарчмыг тайлбарлаж чадсан (Стенсола нар 2012). Энэ үед л бид нэг амьтнаас 200 хүртэл торон эсүүдийг ялгаж торны хэмжээс тогтвортой эсвэл шатлал ахиж нэмэгддэг эсэхийг тодорхойлох боломжтой болсон. Бичлэгт торны зай үл мэдэгдэх шатлалаар нэмэгдэж байв (Зур. 12а). Ерөнхийдөө торны хэмжээс араас өвөрт нэмэгдэж байгаас өмнө нь мэдэж байсан бөгөөд хэмжээс зүйн ердөө дөрвөөс таван төвшин байлаа. Төвшин бүрийг модул болгон авч үзсэн. Электрод дозал талаас вентралд байрлуулахад шинэ модулууд нэмэлтээр бүртгэгдсэн ба медиал энторинал гадрын дорзал хэсэгт хамгийн жижиг модул (M1) байдаг бөгөөд үүнээс бүр вентрал чиглэлд M1 ба M2 аль алийг түүнээс урагшлах тусмаа M1, M2, M3 модулуудыг агуулж байв. M1 модулаас M4 ба M5


чиглэлд агуулагдах эсийн тоо илэрхий буурч байв. Иймээс торон эсийн зай хэмжээс топографийн хувьд зохион байгуулагддаг хэдий ч зураглал нь анатомийн хувьд давхардсан модулуудаас тогтдог хэмээн дүгнэсэн. Үйл ажиллагааны хувьд ижил хүртэхүйн анхдагч гадрууд анатомийн хувьд эрс зааглагдсан бүтэцтэй байдаг бол энэхүү бүтэц нэлээд ялгаатай байв.

Торны хэмжээ болон зэргэлдээх модулуудын уялдаа холбоо юунд оршиж байна вэ? Энэхүү асуултад хариулт олохын тулд бид зэргэлдээ оршиж буй модулуудын торны зай бүрийн харьцааг жишиж судалсан юм (12б). Торны харьцаа харилцан адилгүй байсныг үл тооцвол дундаж харьцаа бараг тогтмол 1,40-с 1,43 хооронд байв. Нэг хос модул бүрт яг л геометр прогресс шиг том модулын хэмжээг жижиг модулын хэмжээг тогтмол коэффициентээр үржүүлэн олох боломжтой байв. Ингээд торны хэмжээсийн зохион байгуулалт нь онолын хувьд орон зайг хамгийн боломжтой дээд нарийвчлал ялгарлаар хамгийн цөөн тооны эсүүдэд кодлох боломжтой хэмээн үзсэн.

4. Ерөнхий зураглал

Лекцийнхээ түүхийн хэсгийг дуусгахын алдад та бүхнийг торон модулуудын үүргийн тогтвортой байдалд анхаарлаа хандуулахыг хүсэх байна. 2007 онд, ойрын хамтрагч SISSA гийн Аллесандро Тревез болон өөрсдийн оюутан Марианн Фин, Торкел Хафтинг нарын оролцоотойгоор нэг зэрэг тэмдэглэгдсэн торны фаз буюу тэнхлэг, торны хэмжээс пропорц, торны чиглэлийн хувьд ямар ч орчин, нөхцөлд өөр хоорондоо хамааралтай байгааг олж мэдсэн юм (Фин нар., Зур.13а). Бид торон бүтцүүд дөрвөлжин эсвэл дугуй орчинд, нэг өрөөнд эсвэл тус тусдаа байхад ямар ижил шинж чанаруудыг харуулдаг болохыг харилцан хамаарлын аргаар бүхий л тэмдэглэгдсэн торон эсүүд дээр туршиж үзсэн билээ (Зур.13б). Өөр, өөр орчныг буулгасан эсүүдийн зураглалын бүтэц орой нь бие даасан нэг эсийн торон хэмжээсийг санагдуулам 6 өнцөгт торон хэмжээстэй байсан билээ (Зур.13в). Энэхүү торон бүтцийн хадгалагдах чанар нь оройн туйлын байрлалын шилжилтийг эс тооцвол, ялгаалтай орчин бүрд алслагдалт нь ижил зайтайд оршиж байв. Хэрэв хоёр эс торон орой нэг орчинд давхцаж байвал тэд өөр нэгэн орчинд ч мөн адил ийм давхцалтай байх бөгөөд хэрэв тэдний фаз нэг орчинд эсрэг чигт байвал нөгөө орчинд ч мөн адил эсрэг

байна. 2012 онд, модулийн нээлтийн дараа бид энэхүү тогтвортой байдал нь нэгэн ижил модул бүхий эсүүдэд хадгалагдах ба өөр модулын эсүүд бол урьдчилан таамаглашгүй орон зайг эзлэх уялдаа холбоотой байдгийг ажигласан юм (Стенсола нар., 2012). Энэхүү үр дүнгээс үзвэл торон модул нь тойм ерөнхий зураг шиг ажилладаг ба амьтад нэг орчноос нөгөөд шилжих бүрт конфигурацаа шинэчилж байдаг байрлалын эс шиг бус орчны тухай жижиг мэдээлэл бүр дээр төвлөрдөггүй гэсэн үг юм (Мюллер ба Куби, 1987). Гиппокампуст зэрэг хийсэн бичлэг энэхүү ялгааг батална. Гиппокампын ялгаат орчны-эсийн харилцан хамаарлын зураглал нь оройтой бүтцийг харуулаагүй ба хоёр орчинд буй зэрэг идэвхждэг байрлалын эсүүдийн бүтэц хоорондоо маш өөр болохыг харж болох юм (Фин нар., 2007).



ЗУРАГ 12. Торон зураглал нь модул бүтэцтэй. (а) Торны хэмжээ далд шатлалаар өсдөг. Зургийн дээд хэсэгт аутокорреляграмаар ялгаатай модулуудын дөрвөн эсүүдийг харуулж байна. Доод хэсэгт нэг амьтны медиал энторинал гадрын бүхий л эсүүдийг дорзал талаас вентрал тал хүртэл бүртгэж судалсан торны зайг харуулж байна. Цэг бүр нэг эсийг илтгэнэ. Эсүүдийг дорзал талаас вентрал тал хүртэл эрэмблэн байршуулсан. Тасархай шугмаар үл харагдах модулуудын дундаж утгыг жагсаан харуулав (модул М1-М4). Эсүүд к-дунджаар кластер үүсгэн модулд хуваарилагдсан алгоритмтай байв. Дээр хэсэгт сумаар дөрвөн өөр модулын эсийн жишээг харуулав. (b) Зүүнд, зэргэлдээх модулуудын хослолыг харьцуулан буулгав. Тойрог бүр бие даасан модулын хослолыг (32 модулууд, 11 харх) илтгэнэ. Модулын хослолын дундаж харьцааг улбар шараар, нийт дунжийг улаанаар харуулсан. Баруунд, торны хэмжээс 4 модулд нэмэгдэж байгааг схемлэн дүрслэв. Модул бүрд дундаж утга хэмжээг өмнөх модулын утгыг тогтмол тоогоор (1.4) үржүүлэн тооцоолж олох боломжтой ба модулын хэмжээсүүд геометр прогресс үүсгэв. Стенсол нарын (2012) болон Мозер нарын бүтээлээс (2014)

Эдгээр ажиглалтууд нь байрлалын эс болоод торон эсүүдийн хоорондын гол ялгааг харуулж байна. Торон модулууд нь нийтлэг шинж чанартай ба тогтвортой-орон зайн хэмжээс бүрт тодорхой давтамжтай, харин байрлалын эсүүд төрөл бүрийн зүй тогтолтой, тухайн орон зайтай холбоотой ой санамж, байрлалын эсийн зураглалд хадгалагдсан байршлуудад зориулагдсан байна (Мозер нар., 2008, 2014).


Эцэст нь, торон эсүүд биологийн зүйл хооронд хэр нийтлэг вэ? Торон эсүүд зөвхөн харханд өвөрмөц биш болохыг баталгаатай хэлж чадна (Зур.14). Торон эсүүд хулгануудад ч мөн бий (Фин нар., 2008). 2011 онд, Начул Уляновскийн баг филогенезийн модний бүүр нөгөө мөчирт байгаа Египтийн жимсний сарьсан багваахайнуудад ч байдаг болохыг олж нээсэн (Ярьцев нар., 2011), дараагаар нь Элизабэт Баффалогийн баг макаки сармагчинд олсон (Киллиан нар., 2012) бол түүний дараагаар Ишжад Фриед болон Майк Кана нарын баг хүнд байдаг болохыг нь олсон байдаг (Жакоб нар., 2013). Тиймд, торон эсүүд бусад орон зайн эсүүдийн адилаар олон зүйлийн хөхтөн амьтдад байдаг ба эволюцийн түүнээс эрт үеүдэд ч мөн байсан байх магадлалтай билээ.

5. Торон эсүүд ба хүрээлэн орчны геометрийн бүтэцзүй

Лекцийн үлдсэн хэсэгт та бүхэнд манай лаборатори одоо ажиллаж буй чиглэлийн талаар танилцуулах болно. Асуултын


хариултыг бүрэн тайлбарлаагүй, урьд нь хэвлэгдээгүй гурван асуудлыг товчхон танилцуулна.

Эхлээд торон бүтэцзүй хүрээлэн орчинтой хэрхэн уялддаг вэ гэдэг асуултыг тавимаар байна. Торон эсүүд тархины дотоод тооцооллын дагуу үүсдэг ба орон зайн зураглал, зүг чиг олох зэрэгт оролцдог, ингэж ажиллахад хүрээлэн орчинтой тогтвортой уялдаа холбоотой ажиллах ёстой болно. Тухайн бодгаль тодорхой нэгэн газарт очиход эдгээр эсүүд тогтвортойгоор нэг талбайд идэвхжих учиртай. Үнэхээр ч ийм зүй тогтол байдаг (Хафтинг нар, 2005) ба орчинтой хэрхэн уялддаг гэдэг зохицуулгыг тайлбарлах шаардлага гарна.




ЗУРАГ 13. Торон зураглалын зүй тогтоц. (а) Амьтны байршил өөрчлөгдөхөд торон эсүүдийн хэмжээ, фаз, чиглэлийн хамаарал хэрхэн хадгалагдаж байгааг схемчлэн харуулав. Гурван ширхэг торон эсүүд өрөө өөрчлөгдөхөд идэвхжлийн

зураглал болоод хамаарал нь хадгалагдаж байдаг болохыг гурван өөр өнгөөр зурж харуулсан. (b) Орчин түүний хамаарлын аргачлалын зураглал. А болон В орчин тус бүрт ялгаатай эсүүдийг гурван хэмжээст матрицаар дүрсэлсэн ба х ба у тэнхлэгээр орон зайг, харин z тэнхлэгээр эсийг дүрсэлж байршуулав. Х ба у тэнхлэг нэг нэгжээр өөрчлөгдөх зайд идэвхжиж буй эсийн векторыг нэг популяци хэмээн тооцсон. Ингээд ижил популяциудын векторыг х ба у тэнхлэг дагуу баг багаар өөрчлөгдөх бүрт харьцуулсан судалсан. (c) Медиал энторинал гадрын нэгэн зэрэг бүртгэгдсэн торон эсүүдийн орчин-хамаарлын матриц тогтоц. Зүүн талд ижил орчныг давтан туршиж (АхА) ажигласан, баруун талд ялгаатай орчнуудыг харуулав (АхВ). Орчин-хамаарлын корреляграмм дүрсэлд нэг орчны давтсан туршилт хамгийн өндөр тодролтой байгаа бол харин орчин солигдсон туршилтад идэвхжлийн талбай нь өөрчлөгдсөн, гэхдээ хамаарлын зураглалын торон бүтцээ хадгалсаар байв. Үүнээс үзвэл орчин солигдоход фаз, хэмжээ, чиглэлийн хамаарал хадгалагдаж үлддэг хэдий ч абсолют фаз эсвэл чиглэл нь ялгаатай (идэвхжлийн орой цэг ялгаатай) ажээ. (d) Гипокампын СА3 гадрын эсүүдийн матрицыг орчны хамаарлаар нь судалсан байдал. Ялгаатай орчинд бүтцээ хадгалахгүй байгааг анзаарч болно, энэ нь хоёр орчинд хамааралгүй зураглалууд бий болдог байна (Фихн нарын бүтээлээс, 2007).



ЗУРАГ 14. Торон эсүүд мэрэгчид, сарьсан багваахай, мич, хүнд зэрэгт бүртгэгдсэнээс үзвэл хөхтөний эволюцийн эхэн үед бий болсоныг харуулна. Крубитзер нарын (2011) бүтээлээс иш татав.




ЗУРАГ 15. Гадаад орчны геометр торон зураглалд нийцэх байдал. (a) Спайк долгионы цэгүүд (дээд эгнээ), орон зайн аутокорреляграм (доод эгнээ)-ыг хэд хэдэн амьтныг 1,5 метр хэмжээтэй шоо дөрвөлжин хашлага дотор байлгаж бүртгэсэн ба 4 торон эсийн мэдээллийн харуулав. Спайк плотод траекторыг саарлаар, спайк нэгжийг хар цэгээр дүрслэв. Аутокорреляграмд өнгөөр кодлож хөхөөс улаанд чиглэхэд хамаарал нэмэгдэж байна. Тасархай шугамаар нэг торны тэнхлэгийн чиглэлийг дүрслэв. Амьтдын болон эсүүдийн чиглэл давтагдаж байгааг ажиглаарай. (b) Зүүн дээр: нэг эсийн орон зайн аутокорреляграм. Төвд байрласан хамгийн эрчимтэй цэг түүнийг тойрсон зургаан өндөр идэвхжлийг хараар дүрслэв. Баруун дээр: 1.5 метр хэмжээтэй шоо дөрвөлжин хашлага дотор 587 торон эсийн чиглэл болон зайг туйлын скаттерплот график дээр дүрслэв. Орон зайн аутокорреляграмд эс болгонд 1+6 байдлаар (зүүн диаграмд хар цэгүүд) хамгийн дотоод талбайг (1+6 цэг бүр эсүүдийг, харлах тутамд давхцалыг илтгэнэ) дүрслэн харуулж байна. Төвөөс алслагдах зай нь торны

хэмжээтэй пропорциональ харьцаатай байдаг. Хайрцагны үндсэн тэнхлэгүүдийг улбар шар болон ногоон өнгөөр зурсан. Тасархай шугам бол энэхүү кардиналь тэнхлэгийн 60 дахин өсгөсөн зураглал юм. Доод талд: Зүүн-баруун чиглэлд 60 дахин өсгөсөн 3 тэнхлэг бүрийн туйлын скаттерплот графикт бүлэглэж кластер болгосон давтамжийн тархалтыг харуулж байна. Стенсола нарын бүтээлээс зөвшөөрөлтэйгөөр нийтлэв (2015).


Орчинтой хамааралтайгаар торон бүтцийн үүсэх чиглэл санамсаргүй бус байдлаар идэвхждэг байна (Стенсола нар 2012, Крупик нар 2014). Тор ба Ханна Стенсола оюутнуудынхаа хамтаар үүнийг дэлгэрүүлж судалсан (Стенсола нар 2015). Эхэн үедээ өөр өөр эсүүдийн торны тэнхлэг нь санамсаргүй байдлаар ижилхэн байгааг олж хараад ихэд гайхсан (Зур 15а). Ихэнх эсүүдэд торны тэнхлэг нь орчны хананы тэнхлэг дагуу хэлбийсэн байдаг ба энэ зүй тогтол өөр амьтнуудад хадгалагдаж ойролцоо хэмээр хэлбийж байв. 6 хархны нийт 587 торон эсүүдийн дээжийг судалж үзвэл 1,5 метр өргөн шоо дөрвөлжин орчинд зөвхөн цөөн тооны торон эсүүд идэвхжиж байв. Энэхүү тархалтыг дүрслэхийн тулд эс бүрт орон зайн аутокорреляграм байгуулж, тус аутокорреляграмын төв болоод зэргэлдээх зургаан оройг гэх мэтчилэн эс бүрт 7 цэгт бүхий цэгэн скаттерплот зурсан (Зур 15b). Тархалтын хувьд кластер бүлэглэлттэй байдаг бөгөөд үүнээс үзвэл торны эсүүд жижиг хэмжээтэй байгааг хэлээд зогсохгүй нэг модулын хэмжээнээс үүдээд модул доторх торон эсүүдийн чиглэл олон тохиолдолд ижилхэн байдаг ажээ.

Эхлээд харахад энэхүү торон эсүүдийн сүлжээ нь хүрээлэн орчинтой симметр бүтэцтэй, жишээ нь орчны хана хойноос урагш, зүүнээс-баруун гэх мэтчилэн адилтгав (Зур.15b). Дэлгэрэнгүй судлаад үзэхэд үгүйсгэгдсэн билээ (Зур16.). Дунджаар торны тэнхлэгийн эхлэл нь тухайн орчны хананы тэнхлэг дагуу 5-10 хэмээр хазайлттай байв. 1.5метр шоо дөрвөлжин хайрцган дотор торны чиглэл хайрцагны зүүн-баруун зүг дагуу + эсвэл - 7,5 хэмийн хэлбийлттэй байсан. Харин 0 эсвэл 15 хэмд бараг ямар ч эсийн эхлэл байгаагүй. Тор ийнхүү дотоод эргэлт нь зүй тогтолтой байсан учир 7,5 хэмийн хэлбийлттэй болгоныг дэлгэрүүлэн судалж, 0 болон 15 хэмд судлах шаардлаггүй нөхцөл байдлыг бүрдүүлсэн билээ.




ЗУРАГ 16. Хайрцагны хана хамгийн жижиг байх нөхцөлд торны тэнхлэгийн чиглэлийн давтамжийн тархалтыг харуулж байна. Зургийн дэлгэрэнгүй цонхонд хананы тэнхлэг дагуу чиглэл тодорхойлогдож байгааг харж болно, Стенсола нар (2015).

Асуултын хариулт бараг л тийм байлаа. 7,5 хэмд орчны тэнхлэг болоод торны тэнхлэгтэй хэлбийлт үүсгэн торон бүтэц эхэлдэг; энэ л хэлбийлт хоёр хананы тэнхлэгийн дагуу үүсэж буй зүй тогтол максимум ялгаа байлаа (Зур.17). Үүнтэй харьцуулвал 0 болон 15 хэмүүдэд хайрцаг болоод торон бүтэц ижил тэнхлэгтэй бөгөөд торон зураглал зарим ханатай ижил бүтэцтэй байв. Энэхүү зүй тогтол нь нэгэн ижил ойролцоо орчин тархинд үүсгэх идэвхжлийн дээд хэмжээ, хэмийг илэрхийлж байгаа болно.



ЗУРАГ 17. Хайрцаг болон торны тэнхлэг 0 болон 15 хэмд симметр давхцалтай байсан бол 7.5 хэмд байгаагүй. Тасархай шугамаар хайрцагны симметри тэнхлэгийг харуулсан (2 үндсэн тэнхлэг болон 2 диагональ тэнхлэг). Улбар шар

шугам өөр эхлэлтэй өөр өнцөг дэх тэнхлэгийн симметри давхцалыг илэрхийлнэ. Улаан шугамд хайрцаг болон торонд аль алинд симметри бүхий тэнхлэгийг харуулсан. Нэг хананаас 7.5 хэм хэлбийхэд хайрцаг болон торны симметри тэнхлэг нь дээд хэмжээндээ алдагдаж симметри байдлаа алдана. Тэгш өнцөгт ханатай орчинд 7.5 хэм хэлбийх нь торон зураглалд хамгийн дээд хэмжээгээр өөрчлөгдөж байж болох юм. Стенсола нарын бүтээлээс зөвшөөрөлтэйгөөр нийтлэв (2015).




ЗУРАГ 18. Эргэлт бий болсоны дараа деформаци үзэгдэнэ. (a) Туйлын скаттерплот график дээр хамгийн ойр хананы тэнхлэг дагуу эсвэл 60-хэм дахин өсгөсөн байдлаар тэнхлэг өвөрмөц идэвхжиж эхлэл бий болдог ажээ. (b) 60 хэмээр өсгөсөн идэвхжлийн цэгүүдийн хамгийн дээд утга. (c) Орон зайн аутокорреляграм дээр симметри торон зураглал болоод деформацид орсон эллипсайд бүтэц харагдаж байна. (d) Эллипс зураглал болоод өнцөглөсөн эхлэлд хүчтэй хамааралтай байгааг скаттерплот дээр харуулав. (c) Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл торны эргэлт болоод торны деформацийн үзэгдэл зэрэг тохиолдож байгаа нь нэг механизмтай байх боломжтой юм. Стенсола нарын бүтээлээс, 2015.

Юу ийнхүү торны жигд эргэлтийн зураглалыг бий болгодог вэ гэсэн асуулт тулгарч байна. Торны гурван тэнхлэг бүрийн эргэлтүүд ялгаатай байдаг нь нэгэн сэжмийг өгсөн юм. Хамгийн ойр байрлах нэг хананы тархинд буух тэнхлэг нь торон зураглалд 7,5 хэм байдаг тухай би дээр тайлбарласан билээ. Нөгөө хоёр тэнхлэгийн хувьд бол хэлбийлт нь бага, хананаас хамгийн хол тэнхлэг гэхэд л 2-3 хэмийн эргэлттэй байдаг (Зур 18ab). Эргэлтийн хэм ингэж ялгаатай байгаа нь торон зураглал тэгш хэмт зургаан

өнцөгт бүтцээ алдаж дотоод талбай нь тойрог бус эллипс дүрсийг үүсгэх учиртай. Торон зураглалын эллипс хэлбэршил болоод торны эргэлтийн зүй тогтол нь хоорондоо ойрхон хамааралтай төдийгүй нэг механизмаар зохицуулагддаг байх болов уу (Зур.18cd)- Ямар зохицуулга байх боломжтой вэ?

Бид нэгэн таамаглал дэвшүүлсэн бөгөөд торны эргэлт болон деформацийг зүсэгдэх/хүрээлэгдэх гэдэг үзэгдлээр тайлбарлах боломжтой - тэнхлэг дэх цэгүүдийн зайнаас пропорц хамараалтайгаар деформаци болж хүрээ тэнхлэгийнхээ дагуу нүүж буудаг болов уу (Масе 1970). Зүсэгдэх гэдэг ойлголтыг эхлээд симметр бүтэцтэй торон зураглалыг зэргэлдээ орших 6 эсүүд үүсгэж эхэлнэ (Зур 19, зүүн).




